



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	5-6
Мөнгө, банк.....	6-7
Үнэ.....	7
Аж үйлдвэр	7-8
Хөдөө аж ахуй	8-9
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	9-10
Эрүүл мэнд.....	10
Гэмт хэрэг.....	11
Цаг уур	11-12

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймагийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймагийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

2017 оны эхний 08 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 5485.2 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1024.4 сая төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна. 2017 оны эхний 08 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Галуут, Эрдэнэцогт, Жаргалант, Баяновоо, Заг, Жинст, Богд, Баян-өндөр, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТ 24 хувь, Агаарын бохирдол /авто/ 32 хувь, Газрын төлбөр 28 хувь, Бууны татвар 49.1 хувь, Түгээмэл тархацтай АМАТ 84.9 хувиар тус тус тасарч, бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2.7 хувь, нэмүү өртгийн албан татвар 4.2 хувь, ЦХТА орлого 50.3 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 7.2 хувь, хүү торгууль 8.6 хувь, бусад төлбөр хураамж 27.0 хувийг эзэлж байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

2017 оны эхний 08 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1126 болж өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар буурчээ. Нийт ажилгүй иргэдийн 57.4 хувь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 76.4 хувь, 45 дээш насныхан 23.6 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой 682 буюу 60.6 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой 137 буюу 12.1 хувь, дээд, магистр, доктор боловсролтой 307 буюу 27.3 хувийг тус тус эзлэж байна.

Эхний 8 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 472 хүн ажилд зуучлагдан орсон нь өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буурчээ. Ажилд орсон иргэдийн 83.6 хувь нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 472 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 46.8 хувь буюу 221 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 78, Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 82, Уул уурхай, олборлолтын салбарт 36, Худалдааны салбарт 6, Барилгын салбарт 57, Төрийн удирдлага ба албан журмын нийгмийн хамгааллын салбарт 110, Боловсролын салбарт 33 бусад салбаруудад 70 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 8 сарын байдлаар нийт 566 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалд 115, Удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 16, Хөдөө аж ахуйн салбарт 84, Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 105, Боловсролын салбарт 35, Барилгын салбарт 66, Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 42, бусад салбаруудад 5-17 ажлын байрны захиалга иржээ.




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2017 оны 08 дугаар сарын 30-ны байдлаар арилжааны банкуудаар 2276.5 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 08 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 136171.7 сая төгрөг байгаагийн 132520.3 сая.төгрөг нь хэвийн зээл, 2569.3 сая.төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2977.2 сая төгрөгийн чанаргүй зээл байна.

Эхний 08 сарын байдлаар иргэдийн хадгаламж 75872.6 сая.төгрөг болжээ. Үүний 19574.5 сая.төгрөг нь хугацаагүй хадгаламж, 55995.8 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна. Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 7895.8 сая.төгрөг болжээ.





ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 08 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф 2016 оны 12 сарынхаас 8.1 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.3 хувиар өсч, өмнөх сарынхаас 1.6 хувиар өссөн байна. Хүнсний бараа ундаа усны бүлгийн дүн 2017 оны 08 дугаар сард өмнөх сарынхтай харьцуулахад 0.4 хувиар буурч, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн дүн 0,1 хувиар, хувцас, бөс бараа, гуталын бүлгийн дүн 0,7 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн дүн 0,8 хувиар, боловсролын үйлчилгээний бүлгийн дүн 36.0 хувиар бусад бараа үйлчилгээний бүлгийн дүн 1,3 хувиар өссөн нь ерөнхий индекс 1.6 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна. Харин хүнсний бараа түүн дотроо мах махан бүтээгдэхүүний үнэ 7.0 хувиар, жимс жимсгэнэ 0.2 хувиар саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны үнэ 5.6 хувиар өмнөх сарынхаас буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР


2017 оны эхний 08 сарын байдлаар аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 3865.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буюу 1129.9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт борлуулалтыг салбараар нь үзвэл Уул уурхай, олборлох аж үйлдвэр 31.0 хувь, Боловсруулах аж үйлдвэр 16.3 хувь, Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 52.7 хувийг тус тус эзлэж байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Ургац хураалтын явцын мэдээллээр аймгийн хэмжээнд 2017 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар 333.7 тонн төмс, 177.4 тонн хүнсний ногоо хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс 69.9 тонн (26.5%)-оор өсөж, харин хураасан хүнсний ногоо 11.8 тонн (6.2%)-оор буурсан байна.






НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Аймгийн Нийгмийн даатгалын сангаас оны эхний 08 сарын байдлаар Өндөр настны тэтгэвэрт 16731.8 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 3558.1 сая төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1215.0 сая төгрөг тус тус олгожээ.

Эдгээр тэтгэвэрүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр настны тэтгэвэр 1906.9 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 411.4 сая төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 40.7 сая төгрөгөөр тус тус өсчээ.

Нийгмийн халамжийн сангаас Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжид 3159 эхэд 632.1 сая төгрөг, Ахмад настныг асарч буй 918 иргэнд 388.1 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй 414 иргэнд 158.0 сая төгрөг, Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний тэтгэмжид 69 хүнд 32.4 сая төгрөг, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 873 ахмадад 165.6 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 375 иргэнд 72.1 сая төгрөг, Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 1745 хүнд 731.3 сая төгрөг, Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 15 ахмадад 19.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэмж өмнөх оны мөн үеэс Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж, Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжууд өсч бусад тэтгэмж хөнгөлөлтүүд өмнөх оны мөн үеэс буурчээ.



ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн эрүүл мэндийн газрын мэдээгээр оны эхний 08 сарын байдлаар 1262 эх амаржиж 1263 хүүхэд төрсөн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал амаржсан эх, төрсөн хүүхэд тус бүр 5.8 хувиар буурчээ.

Аймгийн эрүүл мэндийн салбарт нийт 170214 үзлэг хийгдэж 13312 хүн эмчлүүлсэн байна.

Эхний 08 сарын байдлаар нийт 296 хүний нас баралт бүртгэгдсэн байна. Үүнээс 1 хүртлэх насны эндэгдэл 20, 1-5 насны эндэгдэл 4 бүртгэгджээ. Эдгээрийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал 54.0-57.1 хувиар буурсан байна.

Мөн тайлант сарын байдлаар халдварт өвчний гаралтаар Вируст гепатит, Суулгалт халдварт өвчнүүд өмнөх оны мөн үеээс өсч бусад халдварт өвчин буурсан байна.

Эрүүл мэндийн зарим үзүүлэлт



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 08 сарын байдлаар 314 гэмт хэрэг бүртгэгдсэний 184 нь хөнгөн, 96 нь хүндэвтэр, 31 нь хүнд, 3 нь онц хүнд гэмт хэрэг байжээ. Нийт гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 11.1 хувиар өсчээ. Ингэж өсөхөд голлож хөнгөн, хүнд хэргүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт гэмт хэргээс өмчийн хулгайн хэрэг 105 гарсаныг задлаж харвал:

- Иргэдийн өмчийн хулгай 62
- Малын хулгай 31

- Тээврийн хэрэгслийн хулгай 12 гарсан бөгөөд эдгээр нь өмнөх оноос бүгд өссөн байна.

Гэмт хэргийн улмаас нийт 158 хүн бэртэж гэмтсэн бол 16 хүн нас барсан байна.

Нийт гэмт хэргийн улмаас 577.3 сая.төгрөгийн хохирол учирсанаас 299.4 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлсэн байна. Нийт хохирол өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өссөн бол нөхөн төлүүлсэн хохирол 20.1 хувиар буурчээ.

Нийт гэмт хэрэгт 291 хүн холбогдогчоор татагдсан байна. Гэмт хэрэг үйлдэхдээ 30 холбогдогч бүлэглэж, 81 холбогдогч согтуу байсан байна.

Аймгийн цагдаагийн газрын мэдээгээр 6259 зөрчил гарсан бөгөөд 1084 зөрчлийг шийтгэвэрээр, 4646 зөрчлийг торгуулийн хуудсаар торгосон байна.

Эхний 08 сарын байдлаар 1068 хүн эрүүлжигдсэн бол 222 хүн баривчлагдсан байна.



ЦАГ УУР

2017 ОНЫ 09 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТОЙМ

Агаарын дундаж температур нь хангайн уулархаг нутгаар 10.2-оос 3.5⁰С, тал хээрийн нутгаар 15.2-оос 17.8⁰С, говийн нутгаар 19.7-аас 25.2⁰С-ийн хооронд хэлбэлздэг. Тухайн сарын агаарын дундаж температур 16.0 градустай байдаг.

Хур тунадасны төрлийн хувьд нойтон цас, бороо, аадар бороо орох нь бий. Орох хур тунадасны хэмжээгээр авч үзвэл: Хангайн уулархаг нутгаар 18-36мм, хээр талын нутгаар 15.6-31.4мм, говийн нутгаар 8-12мм хур тунадас ордог. Энэ нь жилд орох хур тунадасны 12 орчим хувийг эзэлдэг.

Хүчтэй салхины давтагдлыг олон жилийн дунджаар авч үзэхэд: Говийн нутгаар 1-2, хээр талын нутгаар 1 гэсэн үзүүлэлттэй байдаг ба хамгийн их хурд говьд 18-20м/сек, тал хээрт 12-14м/сек хүрдэг.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС